



Монгол улсын хөрш улсуудтайгаа харилцах гадаад бодлого

Нийгэм судлал 10-р анги
Багш Д.Уранцэцэг
III улирал.

ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

- Манай улс хөрш аль улсуудтай ямар, ямар чиглэлээр харилцдаг, хамтран ажилладаг талаар сурагчид асуулт гаргаж, багаар ярилцах.
- Манай улсын 2 хөрштэй харилцах гадаад бодлогын нийтлэг, онцлогийг хүснэгтээр илэрхийлэх.
- Манай улсын 2 хөрштэй харилцах чиглэлийг улс төрийн, эдийн засгийн, хүмүүнлэгийн буюу боловсролын, соёлын гэсэн чиглэл бүхий бүдүүвчээр харуулах

ТУЛГУУР ОЙЛГОЛТ

Хөрш орнууд гэж тухайн улс үндэстэнтэй шууд хил залган оршдог, тэр улсын дотоод, гадаад бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход их нөлөө үзүүлдэг улс орнуудыг хэлнэ.

Стратегийн түншлэлийн

Олон тулгуурт

Тэнцвэртэй найрсаг

Сайн хөршийн

Хамтын ажиллагааны

“Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”


“Улаанбаатарын тунхаглал”

“Москвагийн тунхаглал”

ХОЁР ХӨРШТЭЙГЭЭ ХАРИЛЦАХ ЗАРЧИМ



ХОЁР ХӨРШТЭЙГЭЭ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛ



ОХУ-тай харилцах харилцааны үндэс

1993 онд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”

2000 онд “Улаанбаатарын тунхаглал”

2006 онд “Москвагийн тунхаглал”

2009 онд “Монгол улс, Оросын Холбооны Улсын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх тухай Тунхаглал” байгуулсан нь хоёр улсын харилцааны эрх зүйн үндэс болсон юм.

Хятадтай харилцах харилцааны үндэс


1994 онд “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”

2001 онд Стратегийн түншлэл

2013 онд Стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрөө баталсан.


2014 онд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2019.09.03нд Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ.



Энэхүү айлчлал нь Халх голын байлдаанд ялалт байгуулсны 80 жилийн ойгоор хэрэгжиж байгаагаар онцлог болсон юм. Монгол, Оросын харилцаа нэг шат ахин, Найрсаг харилцаа, Иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээнд гарын үсэг зурав.

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 2020.02.27нд БНХАУ-д хүрэлцэн очиж, БНХАУ-ын Дарга Ши Жиньпинтэй уулзлаа



Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга уулзалтын эхэнд “...БНХАУ-д шинэ төрлийн коронавирус (Covid-19)-ний тархалт гарч, Хятадын ард түмэн сэтгэл санааны хохирол амссан явдалд эмгэнэл илэрхийлж, монголчууд “Тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас тэвдэж явахад тэвнээр тусал”, “Зовох цагт нөхрийн чанар танигдана” гэж ярьдаг шигээ эртний сайхан ёсоор энэ удаад хүрэлцэн ирлээ. Монголын ард түмнээс 30 мянган толгой хонь хандивлаж байгаа нь мөнгөн дүнгээс илүүтэй хоёр улсын гүн бат харилцааг хэмжих юм гээд БНХАУ-ын ард түмэнд сайн сайхныг хүслээ.

БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-1

1.Хөрш орнуудын гол шалгууруудыг нэрлэнэ үү?

2.Манай улсын газарзүйн байршлын давуу, сул талуудыг тодорхойлоорой.

№	Давуу талууд	Сул талууд
1.		
2.		
3.		
4.		

БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-2

Монгол улсаас ОХУ-д суралцагчдын тоо (2015-2016 онд)	350	<p>МОНГОЛ УЛС</p>	Монгол улсаас БНХАУ-д суралцагчдын тоо (2015-2016 онд)	200
ОХУ-аас Монголд суралцагчдын тоо (2015-2016 онд)	182		БНХАУ-аас Монголд суралцагчдын тоо	969
Монгол дахь орос иргэдийн тоо	477		Монгол дахь хятад иргэдийн тоо	2045
Хилийн нийт уртын хэмжээ	3543 км		Хилийн нийт уртын хэмжээ	4709 км

1. Манай хоёр хөршийн харилцаа сайжирч байгаа нь Монгол улсын гадаад харилцаанд хэрхэн нөлөөлөх вэ?

2. 1990 оноос өмнө дээрх үзүүлэлтүүд ямар байсан вэ?

БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-3

Дараах баримтыг шинжлээрэй

Улс орон	2014		2015		2016	
	Нийт импорт	Нийт экспорт	Нийт импорт	Нийт экспорт	Нийт импорт	Нийт экспорт
ОХУ	1.549.318	61607	1.020.986	76.872	880.396	55.769
БНХАУ	1.767.916	5.073.399	1.389.941	3.910.121	1.060.919	3.901.620

- 1.Манай улсын хоёр хөрштэйгээ хийж байгаа экспорт, импортын хэмжээнд ямар ялгаа ажиглагдаж байна вэ?
- 2.Хоёр хөрштэй хийж буй экспорт, импортын хэмжээнд ямар динамик өөрчлөлт ажиглагдаж байна вэ?

ГЭРИЙН ДААЛГАВАР

1. Бие дааж хийх даалгавар 1,2,3-г дэвтэртээ хийгээрэй.
2. Сурах бичгийн 129-131 хуудсыг сайн уншиж судлаарай.